



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2015 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 4/42

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны "Журам батлах тухай" 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай" 2010 оны 475 дугаар тушаалын хавсралт дахь Батмөнх овогтой Мөнхзултай холбогдох хэсгийн "Солонгос, Чонбук их сургууль" гэснийг "АНУ, Жоржтаун их сургууль" гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2015 оны A/19 дугаар тушаалын хавсралт дахь Батбадрах овогтой Энхзаяад холбогдох хэсгийн "АНУ, Техас их сургууль" гэснийг "Австрали, Дикин их сургууль" гэж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2015 оны A/265 дугаар тушаалын хавсралт дахь Тогтохбаяр овогтой Батбаярт холбогдох хэсгийн "АНУ, Өмнөд Дакота уул уурхай, технологийн их сургууль" гэснийг "Австрали, Ази номхон далайн олон улсын сургууль" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР